**ХЭНТИЙ АЙМГИЙН**
**УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ**
**ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 02 сарын 27 өдөр Дугаар Б/22 Хэрлэн сум

Э. Мөнхчимэгийг дагалдан ажилтнаар
томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, 50.1 дугаар зүйлийн 50.1.1 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1, 62.3, 62.6, 62.8 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт "Төрийн үйлчилгээний мэргэшлийн бусад байгууллагын албан тушаалын цалингийн доод хэмжээ", 2018 оны 382 дугаар тогтоолын 1, 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан журмууд, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, Төвийн даргын 2026 оны Б/07 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Энхтуяагийн Мөнхчимэгийг 2026 оны 03 дугаар сарын 02-ний өдрөөс Дадал өртөөний ээлжийн техникчийн орон тоонд дагалдан ажилтнаар томилсугай.

2.Э. Мөнхчимэгийн үндсэн цалинг албан тушаалын зэрэглэлийн ТҮМ-4 1347000 төгрөг, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 1 хувь, орон нутагт ажилласаны нэмэгдэл 40 хувь, өдрийн унаа хоолны 5000 төгрөгийн нэмэгдлийг тус тус олгосугай.

3.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ерөнхий нягтлан бодогч /Г.Нямсүрэн/, хүний нөөцийн ажилтан /С. Баясгалан/ нарт даалгасугай.

ДАРГА Б. ХЭРЛЭНЧИМЭГ

Хэнтий аймгийн УЦУОШ-товчоон

зөвлөлд өргөдөл гаргах нь

2026.02.07

Миний бие Энхтуяа овогтой Мөнхгэрэл 1989.02.21-нд Дадал суманд төрсөн. Одоогоор нөхөр 4 хүүхдийн хамт тус сумандаа амьдардаг. Би бүрэн дунд боловсролтой. Дадал сумын ЭМТ-д тогооч Дадал сумын ЕБС-д жижүүрээр тус тус ажиллаж байсан.

Дадал сумын ус цаг уурын өртөөнд өртөөний техникч-р ажиллах хүсэлтэй байна.

Өргөдлийг минь харгалзан үзэж ажлын байраар хангаж өгнө үү.

Өргөдөл гаргасан:

Э. Мөнхгэрэл

утас: 89767930

Хүний нөөцийн ажилтанд

---

Э. Мөнхгэрэл-г 2026 оны 03 дугаар сарын 02 өдрөөс Дадал өртөөний дагалдан техникчээр түр томилох санал

2026. 03. 10

[signature]